



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 678
танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН БУГАТ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Ч.Батдэлгэрийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021363

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Ч.Батдэлгэр Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Ч.Батдэлгэрийн мөрийн хөтөлбөр (.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Ч.Батдэлгэрт

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

**БУЛГАН АЙМГИЙН БУГАТ СУМЫН 2024 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЧИМЭДИЙН БАТДЭЛГЭРИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

1.1 Боловсролын талаар

- 1.1.1 Бүх насны иргэд, нийгмийн салбар бүрийг хамарсан насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцооны бодлогыг баримтлана.
- 1.1.2 Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангах бодлогыг дэмжинэ.
- 1.1.3 Орон нутгийн онцлогт тохирсон үндэсний спортыг дэлгэрүүлэн хөгжүүлэх, хүүхэд багачуудад таатай орчин бүрдүүлэх, сурталчлах бодлогыг барина.

1.2 Хөдөлмөр эрхлэлтийн талаар

- 1.2.1 Залуучуудад бизнес эрхлэхэд шаардлагатай орчин нөхцлийг бүрдүүлэх, бодлогыг дэмжинэ.
- 1.2.2 Өрхийн жижиг үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй иргэдийг зээлийн мэдээллээр хангах, сургалт хөтөлбөрт хамруулах замаар бизнесийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

1.3 Хөдөө аж ахуйн талаар

- 1.3.1 Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зах зээл, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, малчдын сүү, цагаан идээ, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах чадамж, үр өгөөжийг сайжруулах бодлого баримтлана.
- 1.3.2 Иргэдийн төмс, хүнсний ногоо хадгалах зорь бий болгох бодлогыг баримтлана.
- 1.3.3 Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.3.4 Иргэдийг хүнсний ногоо, ногоон тэмжээл тариалах үйл ажиллагааг идэвхжүүлэх, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлэх, нөхцөлийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.4 Төсөв санхүү, эрүүл мэндийн талаар

- 1.4.1 Сумын төсөв, түүний төлөвлөлт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг олон нийтэд нээлттэй санал асуулгаар явуулах, гүйцэтгэлд иргэд хяналт тавих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.4.2 Малчдыг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах, алслагдсан багийн иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг ойртуулах бодлогыг дэмжинэ.
- 1.4.3 Суманд нэн шаардлагатай багш, эмч болон бусад төрийн албан хаагчдыг тогтвор сууршилтай ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх, залуу албан хаагчдыг дэмжих бодлогыг хэрэгжүүлж ажиллана.


1.5 Үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуучлалын талаар

- 1.5.1 Хог хаягдлын цэгийн байршил, энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийх бодлогыг дэмжинэ.
- 1.5.2 Сумын хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах бодлогыг баримтлана.

- 1.5.3 Аялал жуучлалын бүсэд худалдаа үйлчилгээ эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжийн ариун цэврийн байгууламжийг байгальд ээлтэйгээр шинэчлэх, шинээр байгуулахыг бодлогыг дэмжинэ.
- 1.5.4 Эко аялал зуучлалыг хөгжүүлэх, отоглох цэг байгуулах асуудлыг бодлогоор дэмжинэ.
- 1.5.5 Гал түймэр, үерийн хамгаалалтын байгууламж, суваг шуудуу байгуулах асуудлыг бодлогын хүрээнд дэмжинэ.

НУТГИЙН ХӨГЖИЛД ИРГЭДИЙН ОРОЛЦОО

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:



Ч.БАТДЭЛГЭР /99315696/

